- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ-ын санхүүгийн албанаас 2020 оны 3,4 дүгээр улирлын хамруулан шалгалт хийжээ. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 1304646.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13046.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1954839.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19548.4 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2520203.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 127953.6 мянган төгрөгөөр буюу 5,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67,903.7	174,383.2	106,479.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	67,903.7	174,383.2	106,479.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,324,345.8	2,345,819.8	21,474.0
Үндсэн хөрөнгө	2,717,377.6	2,831,690.3	114,312.7
Хуримтлагдсан элэгдэл	(393,031.8)	(485,870.5)	(92,838.7)
Нийт хөрөнгө	2,392,249.5	2,520,203.1	127,953.6
Өр төлбөр	659.1	277.0	(382.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,391,590.4	2,519,926.1	128,335.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,392,249.5	2,520,203.1	127,953.6

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 174383.2 мянган төгрөг болж 106479.6 мянган төгрөгөөр өссөн нь сургуулийн гадна пасадны засварын ажлыг нөөцийн бараа материалаар бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2831690.3 мянган төгрөг болж 114312.7 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 22301.0 мянга, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 22366.4 мянга, НҮБ-ийн хүүхдийг ивээх сангаас үнэ төлбөргүйгээр 69480.3 мянган төгрөгийн ариун цэврийн өрөөг барьж ашиглалтад оруулсан зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2519926.1 мянган төгрөг болж 128335.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 128335.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2083175.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 412012.3 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусламж санхүүжилтийн орлого байна. Тусламж санхүүжилтийн орлого 370918.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 308177.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого данс 64920.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 1954839.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 225697.0 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 116036.9 мянга, төвлөрүүлэх шилжүүлэг 123695.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1969241.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1969241.3 мянган төгрөгөөр тоохон суралцагчдын тоог 1509, ажиллагсдыг 101 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 105046.8 мянган төгрөгөөр бууруулж анх 18641945 мянган төгрөгөөр баталж 2 удаагийн зохицуулалт хийж 1909735.4 мянган төгрөгөөр баталсан байна. Суралцагчдын тоог 1409, ажиллагсдыг 102 орон баталсан байна. Цалин, НДШ, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулан баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 510831.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 472881.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 37949.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 472881.1 мянга, орон нутгийн төсвөөс 37949.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 510830.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 437570.0 мянган төгрөгийг зарцуулж 73260.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 437570.0 мянган төгрөг буюу 85.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 2821,6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 371,4 мянга, хангамж бараа материалын зардлыг 22993.5 мянга, НДШ зардлыг 1437,3 тогтмол зардлыг 563,5 мянга, хангамжийн материалын зардлыг 3714,4 мянга, норматив зардлыг 17848,6 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 8900,2 мянга, бараа үйлчилгээний зардлыг 11571,9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Энэ нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл халдвар хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэх бодис, сургалтын үйл ажиллагааг зогсоосон зэргээс шалтгаалжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 73260,8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээний зардлыг 73260,8 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,909,735,400.0	1,782,703,408.0	127,031,991.0	93.3
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,909,735,400.0	1,782,703,408.0	127,031,991.0	93.3
АРГА ХЭМЖЭЭ 80109 тогтмол зардал	-	-	-	-
Бараа, үйлчилгээний зардал	208,246,100	205,286,599	2,959,501	98.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,246,100	205,286,599	2,959,501	98.6
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	1,318,400	1,145,000	173,400	86.8
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81801 үдийн цай хөтөлбөр	-	-	-	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,295,800	29,785,500	50,510,300	37.1
Бусад урсгал шилжүүлэг	80,295,800	29,785,500	50,510,300	37.1
Төрөөс иргэдэд олгох олгох тэтгэмж, урамшуулал	80,295,800	29,785,500	50,510,300	37.1
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт, сургалтын хэвийн орчин	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,299,486,500	1,259,088,141	40,398,359	96.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,299,036,500	1,259,088,141	39,948,359	96.9
Бараа, үйлчилгээний зардал	1,299,036,500	1,259,088,141	39,948,359	96.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,013,695,600	982,950,643	30,744,957	97.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,712,000	118,941,780	7,770,220	93.9
Хангамж, бараа материалын зардал	17,195,300	16,571,633	623,667	96.4
Норматив зардал	9,548,900	9,513,950	34,950	99.6
Эд хогшил худалдан авах	107,991,200	107,861,800	129,400	99.9
Томилолт, зочны зардал	2,028,900	1,540,000	488,900	75.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,444,000	2,440,500	3,500	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	19,420,600	19,267,835	152,765	99.2
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81835 сургалтын хэвийн ажиллагаа	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,724,800	276,642,832	25,081,968	91.7

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	301,724,800	276,642,832	25,081,968	91.7
Бараа, үйлчилгээний зардал	301,724,800	276,642,832	25,081,968	91.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,122,800	238,857,650	16,265,150	93.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,890,400	23,609,582	8,280,818	74.0
Хангамж, бараа материалын зардал	4,711,600	4,225,600	486,000	89.7
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	9,950,000	50,000	99.5
ХӨТӨЛБӨР 71802 Насан туршийн боловсрол	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80101 сургалтын хэвийн ажиллагаа	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,113,400	10,755,336	8,358,064	56.3
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	19,113,400	10,755,336	8,358,064	56.3
Бараа, үйлчилгээний зардал	19,113,400	10,755,336	8,358,064	56.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,779,600	10,359,936	6,419,664	61.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,097,500	159,400	1,938,100	7.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	236,300	236,000	300	99.9

Эх сурвалж: Төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт3: Шилэн дансны мэдээлэл							
дд	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9			2
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	64	21	11	
	Нийт	27	151	117	21	11	2

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс мэдээллийг байршуулсан. Үүнээс хугацаа хоцорсон 21, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2,5,9 дүгээр саруудын 77062.9 мянган төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 2,4,5,9 дүгээр саруудын 82969.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, нийт 160032.8 мянган төгрөгийн 11 гүйлгээг тус тус мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасныг зөрчиж байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 626.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5600.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлснийг Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2020.06.15-ны өдрийн 82 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	626.0	2	626.0	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	5600.0	2	5600.0	-	-	-
Нийт дүн	4	6226.0	4	6226.0	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Тайлант онд аудитаар нийт 71811.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага 1, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 71811.2 мянган төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Байхгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 71811.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс алдаа зөрчлийн арилгах албан шаардлага 1 хүргүүлж ажиллаа. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 151 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 117, хугацаа хоцроосон 21, хугацаа болоогүй 2, байршуулаагүй 11 мэдээлэл байна.

1. Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс хугацаа хоцроосон 21 мэдээлэл нь тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 1, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ 4, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 4, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ 4, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 2, тушаал шийдвэртэй холбоотой 2, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 2, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт 2 тус тус хоцорсон байна.

2. Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байршуулаагүй 11 мэдээлэл нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,5,9 дүгээр саруудын 77062.9 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 2,4,5,9 дугаар саруудын 82969.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, нийт 160032.8 мянган төгрөгийн 11 гүйлгээг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчиж, "Иж бүрэн байх", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан мэдээллүүдийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 71811.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Байхгүй

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: 2020 оны 12 дугаар сард "Санко Маркетинг Монголиа" ХХК руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч тухайн хөрөнгийг хүлээж аваагүй бөгөөд уг хөрөнгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж зохицуулалт хийсэн байна.

1.2 Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

1.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 4.11, 4.12-г мөрдөж, Нийлүүлэгч ААНБ-аас хөрөнгийг хүлээн авсан үед хүлээн зөвшөөрч үндсэн хөрөнгийн орлогоор бүртгэх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

2. Худалдан авалт болон гэрээний хэрэгжилт

Тус сургуулийн гадна фасадын засварын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний 2.1 "Захиалагч нь ажлын нийт үнэ болох 108000.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 48000.0 мянга, 2021 онд 60000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлнэ", 2.2-д "Урьдчилгаа санхүүжилт 50 хувийг олгох бөгөөд ажлын гүйцэтгэл, тоо хэмжээ, сорьц, сертификат ил далд ажлын актыг фото зургаар баталгаажуулсныг үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгоно" гэсэн заалтуудыг зөрчиж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулалгүй 44880.0 мянган төгрөгийг "Буян Аривжих Од" ХХК руу шилжүүлсэн тул зөвлөмж өгч, дүгнэлтийг хязгаарлав.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", санхүүгийн тайлагналын "Үнэн ба зөв" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байж, Төсвийн тухай хуулийн 41.2.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Байгууллагын даргын 2020.12.10-ны өдрийн Б/118 дугаар тушаалаар 2020 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын комиссыг томилсон байна. Тооллогын комисс нь 2020 онд хүлээж аваагүй 9950.0 мянган төгрөгийн өртөг ухаалаг самбарыг биетээр байгаагаар тоолж, тооллогын тайланд баталгаажуулсан байгаа тул зөвлөмж өгч, дүгнэлтийг хязгаарлав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлагналын “Үнэн ба зөв”, “Бодитой оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

3.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагын жилийн эцсийн тооллого, тооцоог үнэн бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Балансын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад ө баримтгүй 6040000 төгрөгийн 7 гүйлгээ байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

4.3. Өгсөн зөвлөмж: Цаашид аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс худалдан авалт хийхдээ дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлүүлж авах болон E-баримт.mn сайтаар өөрийн байгууллагын нэр регистрээр шивүүлж, худалдан авалтад хяналт тавьж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Цалингийн зардлыг давтан тооцоолоход дараах зөрчил илэрлээ. Тайлант оны ногдуулсан татвар 87858.4 мянган төгрөг байхад 88283.4 мянган төгрөг төлсөн бөгөөд 425.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, мөн 3-р сард 1 ажилтанд 420.0 мянган төгрөгийг илүү мэдээлж 48.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

5.3. Өгсөн зөвлөмж: Цаашид Нийгмийн даатгал болон татварын байгууллагатай улирал бүр тооцоо нийлж, авлага өглөгийн тооцоо нийлж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6. Зардлын данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт: Тайлант онд сургуулийн сургалтын менежер, насан туршийн боловсролын менежер, нийгмийн ажилтан нарт 4-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 60 хувиар бодож 517.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 4.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

6.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

6.3. Өгсөн зөвлөмж: Цаашид үр дүнгийн урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2019 оны Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг мөрдөж, төсвийг үр ашигтай зарцуулах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.НАРАНГЭРЭЛ
ОГНОО: 2021.02.24

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.24

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.24

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			Аудитын код:	
					БНА-2021/59/СТА-ТШЗ	
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургууль			Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
А	1	2	3	4	5	
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2,5,9 дүгээр саруудад 77062.9 мянган төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 2,4,5,9 дүгээр саруудад 82969.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, нийт 160032.8 мянган төгрөгийн 11 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар	
2	2020 оны 12 дугаар сард "Санко Маркетинг Монголиа" ХХК руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлсэн ч тухайн хөрөнгийг хүлээж аваагүй бөгөөд уг хөрөнгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	9950.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар	
3	Тус сургуулийн гадна фасадын засварын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгоходоо гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний 2.1 "Захиалагч нь ажлын нийт үнэ болох 108000.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 48000.0 мянга, 2021 онд 60000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлнэ", 2.2-д "Урьдчилгаа санхүүжилт 50 хувийг олгох бөгөөд ажлын гүйцэтгэл, тоо хэмжээ, сорьц, сертификат ил далд ажлын актыг фото зургаар баталгаажуулсныг үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгоно" гэсэн заалтуудыг зөрчиж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулалгүй 44880.0 мянган төгрөгийг "Буян Аривжих Од" ХХК руу шилжүүлсэн	44880.0	Зөвлөмж, дүгнэлтийг хязгаарлав.	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар	
4	Байгууллагын даргын 2020.12.10-ны өдрийн Б/118 дугаар тушаалаар 2020 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын комиссыг томилсон байна. Тооллогын комисс нь 2020 онд хүлээж аваагүй 9950.0 мянган төгрөгийн өртөг ухаалаг самбарыг биетээр байгаагаар тоолж, тооллогын тайланд баталгаажуулсан байна.	9950.0	Зөвлөмж, дүгнэлтийг хязгаарлав	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар	

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад е баримтгүй 6040.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ байна.	6040.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар
6	Цалингийн зардлыг давтан тооцоолоход дараах зөрчил илэрлээ. Тайлант оны ногдуулсан татвар 87858.4 мянган төгрөг байхад 88283.4 мянган төгрөг төлсөн бөгөөд 425.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, мөн 3-р сард 1 ажилтанд 420.0 мянган төгрөгийг илүү мэдээлж 48.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.	473.3	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар
7	Тайлант онд сургуулийн сургалтын менежер, насан туршийн боловсролын менежер, нийгмийн ажилтан нарт 4-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 60 хувиар бодож 517.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.	517.9	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Загдсүм, Ч.Мэнд-Амар
ДҮН		71811.2			

_____ оОо _____